

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр

№ 25/13

Улаанбаатар хот

**Хувьцаа худалдан авч, хөрөнгө оруулалт хийх,
гэрээ байгуулах эрх олгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, 83 дугаар зүйлийн 83.8 дахь хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.23 дахь заалт болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ТУЗ-ийн 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Тогтвортой байдлын бодлогын хүрээнд төр, олон улсын байгууллага, хувийн хэвшлийн хамтарсан санхүүжилттэй ногоон санхүүжилтийн нэгдсэн тогтолцоонд нэгдэх зорилгоор “Монголын Ногоон санхүүгийн корпораци ББСБ” ХХК-ийн толгой компани болох “Си Жи Эф” ХХК-ийн энгийн хувьцааг энэхүү тогтоолын Хавсралт №1-т заасан нөхцөлийн дагуу худалдан авахыг зөвшөөрсүгэй.
2. “Си Жи Эф” ХХК-тай энэхүү тогтоолын Хавсралт №1-д заасан нөхцөлийн дагуу Хувьцаа захиалгын гэрээ болон Хувьцаа эзэмшигчдийн гэрээ байгуулах, тэдгээрт гарын үсэг зурж баталгаажуулах, шаардлагатай тохиолдолд байгуулсан гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, холбогдох бусад арга хэмжээ авах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
3. “Си Жи Эф” ХХК-тай байгуулсан Хувьцаа захиалгын гэрээ болон Хувьцаа эзэмшигчдийн гэрээний хэрэгжилт, тус компанийн үйл ажиллагааны талаар болон холбогдох бусад мэдээллийг Компанийн ТУЗ-д тухай бүр тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



**Зээлээр эх үүсвэр татан төвлөрүүлэх,
гэрээ байгуулах эрх олгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 20.5 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”) -ийн дэргэдэх Аудитын хорооны 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн АХ-25/03 тоот дүгнэлт болон 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зүгээс өөрийн зээлийн бүтээгдэхүүнүүдийн цар хүрээг тэлэх, харилцагчдынхаа өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангаж, санхүүгийн зах зээлд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд талаал, дотоодын хөрөнгө оруулагчид, санхүүгийн байгууллагаас эх үүсвэр татан төвлөрүүлэх үйл ажиллагааг 2023 оноос эхлэн хэрэгжүүлж буйг дурдсугай.
2. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд Компаниас дор дурдсан санал ирүүлсэнтэй танилцаад:
 - 2.1. Компанийн зээлийн бүтээгдэхүүнүүдийн цар хүрээг тэлэх, түүний харилцагчдын өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангах зорилгоор Компанийн нийт зарласан болон гаргасан хувьцааны 75 (далан тав) хувийг эзэмшдэг “АНД ФСЖ Пти. Лтд” (цаашид “Толгой компани”) нь “Lendable Asset Management LLC” -ийн төлөөлөлтэй олон улсын хөрөнгө оруулагчид (цаашид хамтад нь “Санхүүжүүлэгч тал”) -аас авах нийт 20 сая ам.доллар хүртэл зээлийн санхүүжилт (цаашид “Санхүүжилт”) -ийг олон талт, урт хугацаат зээлийн гэрээ (цаашид “Олон талт зээлийн гэрээ”) байгуулах замаар үе шаттай татан төвлөрүүлэхээр, Санхүүжүүлэгч талтай харилцан тохиролцоонд хүрсэн болохыг;
 - 2.2. Толгой компани нь Санхүүжүүлэгч талаас авах нийт Санхүүжилтийг Компани руу дамжуулан зээлдүүлэх зорилгоор Компанитай Хувьцаа эзэмшигчийн зээлийн гэрээ (цаашид “Толгой компанийн зээлийн гэрээ”) байгуулах саналтай байгааг;
 - 2.3. Компани нь Толгой компанийн зээлийн гэрээ байгуулах замаар Санхүүжилтийг хүлээн авах, улмаар Санхүүжилтийг үйл ажиллагаандаа ашиглаж, өөрийн зээлийн бүтээгдэхүүнүүдийн цар хүрээг тэлэх, харилцагчдын өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангах зорилгоо хэрэгжүүлэх үүднээс нийт 10 сая ам.долларын эхний санхүүжилтийг авах хүрээнд:
 - (а) Толгой компани болон Санхүүжүүлэгч талтай энэхүү тогтоолын Хавсралт 1А-д төслийг хавсаргасан Олон талт зээлийн гэрээг байгуулж, Толгой компанийн Санхүүжүүлэгч талын өмнө хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг Олон талт зээлийн гэрээнд заасан нөхцөл бий болсон тохиолдолд хариуцахаар батлан даагчийн үүрэг хүлээх;

- (б) Толгой компанитай энэхүү тогтоолын Хавсралт 1Б-д төслийг хавсаргасан Толгой компанийн зээлийн гэрээ байгуулж, зээлдэгчийн үүрэг хүлээх;

(цаашид хамтад нь “Гэрээний багц”)

шаардлагатай байгаа болохыг тус тус тэмдэглэсүгэй.

3. Тус тогтоолын 2.3-т заасан Гэрээний багцыг Санхүүжүүлэгч тал, Толгой компани болон бусад холбогдох талуудтай байгуулж, хэрэгжүүлэх нь гагцхүү Компанийн ашиг сонирхлын төлөө бөгөөд Компанийн хөрөнгө оруулагчдын хувьд үр ашигтай шийдвэр мөн гэж дүгнэж буй тул Гэрээний багцыг байгуулахыг Компанид зөвшөөрсүгэй.
4. Олон талт зээлийн гэрээ болон түүний нөхцөлийг Хавсралт 1А-д заасан хувилбараар баталсугай.
5. Толгой компанийн зээлийн гэрээ болон түүний нөхцөлийг Хавсралт 1Б-д заасан хувилбараар баталсугай.
6. Гэрээний багцад багтаж буй гэрээ, түүнчлэн эдгээртэй дагалдах бусад гэрээ, хэлцлийг холбогдох талуудтай эцэслэн тохиролцож байгуулах, Багц гэрээний дагуу аливаа баримт бичиг үйлдэх, тэдгээрт гарын үсэг зурж баталгаажуулах, эдгээртэй холбогдох шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
7. Гэрээний багцыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тус багцад багтаж буй аливаа гэрээ, хэлцэлд дурдсан зөвшөөрөл, хүсэлт, мэдэглэл болон үүгээр хязгаарлагдахгүйгээр Компанийн нэрийн өмнөөс үйлдвэл зохих аливаа баримт бичгийг үйлдэх, тэдгээрт гарын үсэг зурж баталгаажуулан холбогдох талд хүргүүлэх, хариу хүлээн авах зэрэг бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
8. Гэрээний багц түүнтэй холбогдуулан үйлдсэн аливаа баримт бичгийн хэрэгжилт, Санхүүжилт татан төвлөрүүлэлт болон ашиглалт, холбогдох бусад мэдээллийг Компанийн ТУЗ-д тухай бүр тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.
9. Энэхүү тогтоолыг Монгол Улсын Компанийн тухай хуульд заасан шаардлагын дагуу Толгой компанитай сонирхлын зөрчилгүй ТУЗ-ийн гишүүдийн шийдвэрээр баталсан болохыг дурдсугай.

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

	/Ж.ЖАРГАЛСҮРЭН/		/С.БОРГИЛ/
	/С.НЭРГҮЙ/		/Ц.ОДМАА/
	/С.ЭНХ-АМГАЛАН/		



ЛЭНДМН БЭСЭЖУ
УЛААНБААТАР ХОТ
5039754 ☎ 1118267208

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.23 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 25/14 тоот тогтоол, 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн эцнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн нийт зарласан болон гаргасан хувьцааны 75 (далан тав) хувийг эзэмшдэг “АНД ФСЖ Пти. Лтд” (цаашид “Толгой компани”) нь “Lendable Asset Management LLC”-ийн төлөөлөлтэй олон улсын хөрөнгө оруулагчид (цаашид хамтад нь “Санхүүжүүлэгч тал”)-аас авах нийт 20 сая ам.доллар хүртэл зээлийн санхүүжилт (цаашид “Санхүүжилт”)-ийг Толгой компани нь олон талт, урт хугацаат зээлийн гэрээ (цаашид “Олон талт зээлийн гэрээ”) байгуулах замаар үе шаттай татан төвлөрүүлэхээр, Санхүүжүүлэгч талтай харилцан тохиролцоонд хүрсэн болохыг тэмдэглэсүгэй.
2. Компанийн ТУЗ-ийн 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 15/14 тоот тогтоолоор Толгой Компанийн тухай бүр татан төвлөрүүлэх Санхүүжилтийг Толгой компаниас зээлдэн авч, Компанийн зээлийн бүтээгдэхүүнүүдийн цар хүрээг тэлэх, түүний харилцагчдын өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангахад ашиглах зорилгоор нийт 10 сая ам.долларын эхний санхүүжилтийг авах хүрээнд:
 - 2.1. Толгой компанитай Хувьцаа эзэмшигчийн зээлийн гэрээ (цаашид “Толгой компанийн зээлийн гэрээ”) байгуулахаар;
 - 2.2. Толгой компани болон Санхүүжүүлэгч талтай Олон талт зээлийн гэрээг байгуулахаар;тус тус шийдвэрлэж, эдгээр гэрээг Санхүүжүүлэгч тал, Толгой компани болон бусад холбогдох талуудтай байгуулахыг Компанид зөвшөөрсөн болохыг дурдсугай.
3. Компани нь Олон талт зээлийн гэрээ болон Толгой компанийн зээлийн гэрээ байгуулах замаар Санхүүжилтийг хүлээн авах, улмаар Санхүүжилтийг үйл ажиллагаандаа ашиглахад дор дурдсан гэрээ, хэлцлийг байгуулах санал ирүүлсэнтэй танилцаад:
 - 3.1. Санхүүжүүлэгч талтай энэхүү тогтоолын Хавсралт 1А-д төслийг хавсаргасан Хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ байгуулж, Олон талт зээлийн гэрээний дагуу Толгой компанийн Санхүүжүүлэгч талын өмнө хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг бүхэлд нь тэргүүн ээлжинд баталгаажуулахаар барьцаалуулагчийн үүрэг хүлээх;
 - 3.2. Дээрх 3.1 дэх хэсэгт дурдсан Хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээний дагуу холбогдох банкны данс барьцаалах гурван талт гэрээг Санхүүжүүлэгч тал болон банкуудтай байгуулах;

- 3.3. Санхүүжүүлэгч талтай энэхүү тогтоолын Хавсралт 1Б-д төслийг хавсаргасан Эрх шилжүүлэх гэрээ байгуулж, эрх шилжүүлэгчийн үүрэг хүлээх;
- 3.4. Санхүүжүүлэгч талтай энэхүү тогтоолын Хавсралт 1В-д төслийг хавсаргасан Дата дамжуулах гэрээ байгуулж, дата өмчлөгчийн үүрэг хүлээх;
- 3.5. Олон талт зээлийн гэрээнд заасан үүргээ биелүүлэх хүрээнд энэхүү тогтоолын Хавсралт 1Г-д төслийг хавсаргасан Хеджинг гэрээ түүнд дагалдах бусад гэрээ, хэлцлийг “MFX Solutions, Inc” компани болон хеджийн харилцаанд оролцогч бусад талтай байгуулж, хеджерийн үүрэг хүлээх;

(цаашид хамтад нь “Дагалдах гэрээний багц”)

шаардлагатай байгаа болохыг тус тус тэмдэглэсүгэй.

4. Тус тогтоолын 3-т заасан Дагалдах гэрээний багцыг Санхүүжүүлэгч тал, Төлий компани болон бусад холбогдох талуудтай байгуулж, хэрэгжүүлэх нь гагцхүү Компанийн ашиг сонирхлын төлөө бөгөөд Компанийн хөрөнгө оруулагчдын хувьд үр ашигтай шийдвэр мөн гэж дүгнэж буй тул Гэрээний багцыг байгуулахыг Компанид зөвшөөрсүгэй.
5. Хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ болон түүний похцолийг Хавсралт 1А-д заасан хувилбараар баталсугай.
6. Эрх шилжүүлэх гэрээ болон түүний похцолийг Хавсралт 1Б-д заасан хувилбараар баталсугай.
7. Дата дамжуулах гэрээ болон түүний нөхцөлийг Хавсралт 1В-д заасан хувилбараар баталсугай.
8. Хеджинг гэрээ болон түүний нөхцөлийг Хавсралт 1Г-д заасан хувилбараар баталсугай.
9. Дагалдах гэрээний багцад багтаж буй гэрээ, түүнчлэн эдгээртэй дагалдах бусад гэрээ, хэлцлийг холбогдох талуудтай эцэслэн тохиролцож байгуулах, баримт бичиг үйлдэх, тэдгээрт гарын үсэг зурж баталгаажуулах, эдгээртэй холбогдох шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
10. Дагалдах гэрээний багцыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тус багцад багтаж буй аливаа гэрээ, хэлцэлд дурдсан зөвшөөрөл, хүсэлт, мэдэгдэл болон үүгээр хязгаарлагдахгүйгээр Компанийн нэрийн өмнөөс үйлдвэл зохих аливаа баримт бичгийг үйлдэх, тэдгээрт гарын үсэг зурж баталгаажуулан холбогдох талд хүргүүлэх, хариу хүлээн авах зэрэг бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.

11. Дагалдах гэрээний багц болон түүнтэй холбогдуулан байгуулсан бусад гэрээний хэрэгжилт, холбогдох бусад мэдээллийг Компанийн ТУЗ-д тухай бүр тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

